



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 11 сарын 19 өдөр

Дугаар А/516

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын "а", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Монгол улсын Засгийн газрын 2020 оны "Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай" 181 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Коронавирус /COVID-19/ цар тахлын өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, ажиглах, тусгаарлах, бэлэн байдлын нөөц бүрдүүлэх зардлыг хавсралтаар баталсугай.

2.Дээрх зардалд зарцуулагдах 96,762,000 (Ерэн зургаан сая долоон зуун жаран хоёр мянга) төгрөгийг гамшгаас хамгаалах зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (И.Доржсүрэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101149

Аймгийн Засаг даргын 2020 оны...
дүгээр сарын ...-ны өдрийн ...
дугаар захирамжийн хавсралт

"КОВИД 19" ЦАР ТАХЛЫН БЭЛЭН БАЙДЛЫН АЙМГИЙН ХЭМЖЭЭНИЙ
НӨӨЦ БҮРДҮҮЛЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Шаардагдах хэрэгцээний нэр, төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Комбинзон хамгаалах хэрэгслийн иж бүрдэл	ш	1000	25000	25,000,000
2	Амны хаалт	ш	20000	300	6,000,000
3	Нэг удаагийн бээлий	ш	5000	700	3,500,000
4	Усны гутал	ш	100	25000	2,500,000
5	Аюулгүй хог хаягдал зөөврлөх уут	ш	500	5500	2,750,000
6	Цогцос хадгалах уут	ш	30	14000	420,000
Хамгаалах хэрэгслийн дүн					40,170,000
7	Эм эмнэлгийн хэрэгсэл	ком	1	23,500,000	23,500,000
8	Халдваргүйтгэл ариутгалын бодис	ком	1	33,092,000	33,092,000
Нийт зардлын дүн					96,762,000